

Түүх 10 : Стефаны үхэл

Библийн эшлэл
[Үйлс 7:59]

Тэд Стефан уруу чулуу шидэлж байхад Стефан Эзэнийг дуудан, Эзэн Есүс минь, сүнсийг минь хүлээн аваарай гэв.

Есүс амилсаны дараа дагалдагч нар нь Бурханы үгийг хичээнгүйлэн дамжуулж эхэлсэн.

Есүсийн дагалдагч нар Бурханы үгийг дамжуулж эхэлснээр итгэгч хүмүүс бага багаар нэмэгдэж байв.

Дагалдагч нар сүмийн ажлыг даалгахын тулд долоон үйлчлэгчийг сонгов.

Тэр дунд итгэлийн хувьд маш сайн Стефан гэгч хүн байв. Стефаны нэр нь “Алдарын титэм” гэсэн утгатай байв.

Стефанаар дамжуулан Бурханы олон гайхамшигууд бий болсон. Тэр чөтгөрийг зайлуулж, өвчтэй хүнийг эдгээж байв.

Тиймээс олон хүмүүс түүнийг дагав. Стефан Бурханы өгсөн мэргэн ухаанаар олон хүнд үгийг дамжуулж тайлбарлаж байв.

Түүнийг дагах хүмүүсийн тоо ч ихсэж байлаа.

Гэтэл нэгэн өдөр Стефанд атаархаж дургүйцдаг хүмүүс түүнийг Иудейн удирдагч нарт гүтгэн ховлов.

“Стефан Бурханы үгийг зөрчсөн” гэж худал ховлов. Стефан Иудейн удирдагчийн өмнө чирэгдэн очив.

Тэр газар цугларсан хүмүүс Стефаныг хараад зогсож байв. Гэтэл Стефаны царай тэнгэр элч адил маш амар тайван харагдаж байв.

Тэр үеийн Иудейн шашинд Бурханы үгийг эсэргүүцвэл чулуу шидэж алдаг хуультай байлаа.

Стефаныг үзэн яддаг хүмүүс Стефанд атаархсандаа энэ үхлээр үхээсэй хэмээн бодсон учраас ингэж барьж өгсөн байлаа.

Стефан хэнээс ч айлгүйгээр маш зоригтойгоор Бурханы үгийг дамжуулж эхлэв. Хүмүүс Стефан уруу чулуу шидэлж эхлэв.

Стефан өвдөг сөгдөн залбирав. “Эзэн минь, намайг хүлээн аваач, харин энэ хүмүүсийг уучилж өгөөч.”

Ингээд Стефан амьсгал хураав. Стефан үхэх хүртлээ Бурханы үгийг дамжуулж байлаа.

Тэрээр анхны чуулганы үед Бурханы төлөө амиа зориулсан анхны хүн болсон юм.

- Дараах библийн эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (Үйлс 7:59)

Эзэн Есүс минь, сүнсийг минь хүлээн аваарай гэв.



Стефаны зургийг зөв байрлуулахын тулд дээрх зургийг сайтар ажиглаж, доорх хоосон дөрвөлжин дотор зөв дугаарыг бичээрэй.



Стефаныг чуулганы ажлыг даалгах үйлчлэгчээр сонгосон.



Стефан маш олон гайхамшгийг үйлдэж байсан.




Стефан, өөрийг нь үзэн яддаг хүмүүст баригдсан.



Стефан хэнээс ч айлгүйгээр сайн мэдээг тараасан.



Стефан руу хүмүүс чулуу шидэлж байсан.



Стефан үхэх хүртэлээ сайн мэдээг тунхаглаж байсан.



